**ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНЫ ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

| Д/д | № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Суурь | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин | Эхэлсэн, дуусах хугацаа | Биелэлт хувь |
| ЗОРИЛГО 5. Төрийн захиргааны удирдлагын манлайлал, хүний нөөцийн удирдлагаар хангах, байгууллагын хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг оновчтой удирдах, тайлагнах, албаны үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам, стандарт боловсруулах, батлуулах, мөрдүүлэхэд эрх зүйн дэмжлэг үзүүлэх, салбарын хэмжээнд байгуулагдах гэрээ, хэлэлцээр хийх ажлыг зохион байгуулах, салбарыг сурталчлах, хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудлыг эрхлэх, гадаад орнууд, олон улсын геологийн алба, байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх | | | | | | | | |
| Зорилт 5.1. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах | | | | | | | | |
| 1 | 5.1.1 | Засгийн газрын 2005 оны Иргэдийн өргөдөл гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай 67 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах, удирдах дээд байгууллагад хүргүүлнэ. | Шийдвэрлэлтийн хувь | 0 | 99% | 2024 оны жилийн эцсийн байдлаар өргөдөл гомдол 23 байна. Үүнээс хүний нөөцийн чиглэлээр албан хаагчдаас ирүүлсэн өргөдөл 21, Гео-мэдээллийн төвөөс мэдээлэл хүссэн 1 өргөдөл, Геологийн баримтын төв архиваас мэдээлэл хүссэн 1 өргөдөл байна.<br>Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн 100% байна.<br>-Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн өргөдөл гомдлын цахим сайтад ҮГА-д холбогдох гомдол 2024 оны жилийн эцсийн байдлаар ирээгүй.<br>-“Төв эрдэнэ сант” ХХК-ийн нэхэмжлэлтэй Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтэст холбогдох захиргааны хэрэгт гуравдагч этгээдээр шүүх хуралдаанд оролцож байна.<br><br>Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн 100% байна. | 2024.01.01-2024.12-15 | 100% |
| 2 | 5.1.2 | Төрийн албан хаагчийн мэдээ мэдээлэл, шилжилт хөдөлгөөнийг зохион байгуулж, Төрийн | мэдээ тайлангийн тоо | 2 | 2 болон түүнээс дээш | Төрийн албаны зөвлөлд 2023 оны мэдээллийг 2024.01.03-нд цахим хэлбэрээр хүргүүлсэн.<br>-Тайлант хугацаанд Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн программд албан хаагчдын мэдээлэлд шаардлагатай өөрчлөлт хөдөлгөөнийг бүртгэсэн. Үүнд: | 2024.01.01-2024.12-15 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | албаны зөвлөлд тайлагнана. | | | | Ажлаас чөлөөлөгдсөн 9, ажилд томилогдсон 7, жирэмсний болон амаржсаны амралт олгосон 1, хавсран гүйцэтгүүлсэн 3 нийт давхардсан тоогоор 31 албан хаагчийн хөдөлгөөнийг бүртгэсэн.<br>-ЗГ-ын Төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай 2024 оны 128 дугаар тогтоолын дагуу Төрийн албаны хүний нөөцийн программ шинэчлэгдсэнтэй холбогдуулан дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үр дүн:<br>1.Нийт албан хаагчдын хувийн мэдээллийг шинэчилж, цалин хөлсний мэдээллийг хүний нөөцийн системд оруулснаар, ЗГ-ын тогтоолд нийцүүлэн цалинжуулах боломжтой болсон.<br>2.Бүх ажилчдын ажилласан хугацааг Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн бүртгэлтэй нэг бүрчлэн тулгаж үнэн зөв бүртгэсэн.<br>ТАЗ-ын хүний нөөцийн системд шивэгдэж орсон албан хаагчийн цалин хөлсний талаар:<br>Хүрсэн түвшин: ЗГ-ын 128 дугаар тогтоолоор батлагдсан цалингийн нэмэгдэлтэй уялдуулан Албаны даргын 2024.04.01-ний өдрийн А/22 дугаар тушаалаар Төрийн үйлчилгээний /ТҮ болон ТҮМ/ нийт 19 албан хаагчийн, А/23 дугаар тушаалаар нийт 10 төрийн жинхэнэ албан хаагчийн цалингийн нэмэгдлийг тус тус баталгаажуулж, албан хаагчдын цалингийн хэмжээг хуульд нийцүүлэн нэмэгдүүлсэн | | |
| 3 | 5.1.3 | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Үндэсний геологийн албаны нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогыг мэдүүлгийг https://meduuleg.iaac.mn цахим хуудсаар шинэчлэн бүртгүүлж | Мэдүүлэг гаргасан албан тушаалт-ны тоо | 0<br><br>0 | 17<br><br>1 | Үндэсний геологийн албаны албан хаагчдын 2023 оны ХАСХОМ-ийг хуульд заасан хугацаанд шинэчлэн гаргуулж холбогдох тайлан мэдээг цахим системд нэгтгэх чиглэлээр дараах ажлуудыг гүйцэтгэлээ. Үүнд:<br>1. Байгууллагын тайлан мэдээг үнэн зөв бодитой гаргах үүднээс http://meduuleg.iaac.mn системд хандаж 2023 оны ХАСХОМ-ийг шинэчлэн гаргасан мэдүүлэг бүрийг хянаж баталгаажуулсан.<br>2. Цахим системд “ХАСХОМ хүлээн авсан тухай бүртгэл”, “Мэдэгдэл тайлбар тэдгээрийн шийдвэрлэлтийн бүртгэл”, “ХАС-ын урьдчилсан мэдүүлгийн бүртгэл” зэрэг бүртгэлийг мэдүүлэгч гаргагч тус бүрээр бүртгэсэн. | 2024.01.01-2024.12-15 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | баталгаажуулах ажлыг зохион байгуулах, холбогдох тайланг боловсруулж, Авлигатай тэмцэх газарт хүргүүлнэ. | | | | 3. Цахим системд ХАС-ын хураангуй, ХОМ-ын хураангуй тайланг уншуулж, PDF файлаар enkhjin@iaac.mn и-мэйл хаягаар хүргүүлсэн.<br>4. Тус албаны албан хаагчдын хувийн ашиг сонирхолын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн 2023 оны тайлан буюу ХАСХОМ-1 тайланг гаргаж 2024-02-28-ны өдрийн 1/146 тоотоор АТГ-т хүргүүлсэн<br>• 2024 оны хагас жилийн байдлаар ХАСХОМ гаргавал зохих 19 төрийн захиргааны албан хаагч байхаас 4 сул ажлын байр нөхөгдөөгүй тул 15 албан хаагчийн ХАСХОМ-ыг шаардлагатай засвар, өөрчлөлтийг хийлгүүлэн, хуулийн хугацаанд баталгаажуулах ажлыг гүйцэтгэсэн.<br><br>• Тайлант хугацаанд хөрөнгө, орлогод орсон их хэмжээний өөрчлөлт 1-ийг бүртгэсэн. Шинээр томилогдох болон ажил хавсран гүйцэтгэхтэй холбоотой 3 албан хаагчийн ХАСУМ эрх нээх хүсэлтийг хүргүүлж шийдвэрлүүлсэн.<br><br>• ҮГА-ны Авлигын эсрэг үйл ажиллагааны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулсан.<br><br>• Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу хөрөнгө оруулгын мэдүүлгийг гаргах, бүртгэх, хадгалах зарим эрх зүйн зохицуулалтууд шинэчлэгдсэнтэй холбогдуулан АТГ-аас зохион байгуулсан сургалтуудад хамрагдсан. | | |
| 4 | 5.1.4 | Гадаадын ижил төстэй байгууллагуудтай байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийн хэрэгжилтийг хангаж, хамтын ажиллагааг идэвхжүүлнэ. | БНПУ, БНСУ, БНФУ-ын үндэсний геологийн албадтай хэрэгжүүлсэн ажлын тоо | 0 | 3 | 2021 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр байгуулсан “Хамтран ажиллах тухай Үндэсний геологийн алба болон Польшийн геологийн хүрээлэн хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн хүрээнд “Бэлийн булаг, Задгай булаг дахь молибден, гянтболд судлах төсөл хэрэгжүүлэх тухай гүйцэтгэлийн гэрээ”-г 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр байгуулсан. Төслийг 2024-2026 онуудад хэрэгжүүлэх бөгөөд 2024 онд гүйцэтгэх хээрийн судалгааны бэлтгэл ажлыг хангасан.<br><br>2022 оны 09 сарын 28-ны өдөр байгуулсан “Дэлхий судлалын чиглэлээр хамтран ажиллах тухай Монгол Улсын Үндэсний геологийн алба, БНСУ-ын Гео шинжлэх | 2024.01.01-2024.12-15 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ухаан, эрдэс баялгийн хүрээлэн хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг"-ийн хүрээнд талууд Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын нутагт байрлах Хаг талбайд ховор металлын эрэл судалгааны ажил гүйцэтгэх зорилгоор "Хамтран ажиллах гэрээ"-г 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрөөс 10 дугаар сарын 03-ны өдрийг хүртэл хээрийн судалгааны ажлыг гүйцэтгэсэн.<br><br>2023 оны 10 дугаар сарын 23-ны өдөр байгуулсан "Геологийн шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны чиглэлээр хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газрын Хэрэгжүүлэгч агентлаг Үндэсний геологийн алба, БНФУ-ын Геологи, уул уурхайн судалгааны товчоо хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг"-ийн хүрээнд "Литий Монгол" судалгааны хамтарсан төслийг эхлүүлж эхний хээрийн судалгааны ажлыг зохион байгуулсан. Төсөлд ҮГА-аас гадна ШУА-ийн Геологийн хүрээлэн, ШУТИС, МУИС-ийн төлөөллүүд хамтран оролцож байна. | | |
| 5 | 5.1.5 | Дотоод, гадаадын ижил төстэй байгууллага, эрдэм шинжилгээний хүрээлэн, байгууллагуудтай хамтын ажиллагааг эхлүүлэх ажлыг зохион байгуулах, хамтарсан төсөл хөтөлбөр хэрэгжүүлнэ. | Шинээр байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичиг, хамтын ажиллагааны гэрээ /тоогоор/ | 0 | 2 | "Геологийн шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны чиглэлээр хамтран ажиллах тухай Монгол Улсын Үндэсний геологийн алба, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын Судалгаа Инновацийн газрыг төлөөлж Британийн геологийн алба хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг"-ийг тус улсын Гадаад хэргийг сайд Д.Камерун 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр Монгол Улсад хийсэн албан айлчлалын үеэр байгуулсан бөгөөд хамтарсан судалгааны ажлыг 2025 оны I дүгээр улиралд гүйцэтгэхээр айлын талтай эцэслэн тохирсон.<br>Канад Улсын Геологийн албаны удирдлагуудтай уулзаж байгууллага хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг байгуулахаар тохирсон бөгөөд санамж бичгийн төслийг Канадын талд хүргүүлсэн. Мөн Канад Улсын Байгалийн яамны техникийн хамтын ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд 2024-2025 онд агаарын геофизикийн чиглэлээр хамтарсан төсөл хэрэгжүүлэх шийдвэр албажсан болно. Уг төслийн хүрээнд Канадын геологийн албаны 2 мэргэжилтэн Улаанбаатар хотноо хүрэлцэн ирж хамтарсан хээрийн судалгааны ажил гүйцэтгэхээр төлөвлөж байна. | 2024.01.01-2024.12-15 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Үндэсний геологийн алба болон Монгол Улсын Шинжлэх ухааны академи хоорондын хамтын ажиллагааны санамж бичиг”-ийг 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр байгуулсан. Уг санамж бичгийн хүрээнд Одон орон геофизикийн хүрээнтэй хамтран "Хүрээлэн орчны гамшгийн эрдэс” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний анхдугаар бага хурлыг Булган Архангай аймгуудын нутаг 2024 оны 8 дугаар сарын 16-20-ны өдрүүдэд зохион байгуулсан.<br>“Геологи, уул уурхайн салбарын мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, чадавхжуулах болон хамтарсан сургалт, судалгааг хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах тухай Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Үндэсний геологийн алба болон МУИС-ийн Шинжлэх ухааны сургууль хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг 2024 оны 04 дугаар сарын 05-ны өдөр байгуулсан. Уг санамж бичгийн хүрээнд тус сургуулийн 2 багш ҮГА, ГСШТ ажилтан албан хаагчдад Петрографи, минерграфикийн сургалтыг 2024 оны 06 дугаар сары 8-ны өдрөөс 07 дугаар сарын 5-ны өдрүүдэд зохион байгуулсан.<br>“Геологи, уул уурхайн салбарын мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, чадавхжуулах болон хамтарсан сургалт, судалгааг хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах тухай Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Үндэсний геологийн алба болон ШУТИС-ийн Геологи, уул уурхайн сургууль хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдөр байгуулсан. Уг санамж бичгийн хүрээнд геологийн салбарын хүний нөөцийн бодлогыг дэмжих зорилгоор уг чиглэлээр амжилттай суралцаж буй 5 оюутны 1 жилийн сургалтын төлбөрийг шийдвэрлэсэн. | | |
| 6 | 5.1.6 | Монгол Улсад Геологийн салбар үүсэж хөгжсөний 85 жилийн арга хэмжээ зохион байгуулна. | Хэрэгжүүлсэн ажлын тоо | 0 | 1 | Монгол Улсад Геологийн салбар үүсэж хөгжсөний 85 жилийн арга хэмжээ зохион байгуулах бэлтгэл ажлыг хангав. Ойн арга хэмжээний хүрээнд Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Үндэсний геологийн алба, Монголын Геологийн холбоодын нэгдсэн зөвлөл хамтран “Геологичдын ажил мэргэжлийн уралдаан”-ыг 09-сарын 27-ноос 09-р сарын 30-ны өдрүүдэд Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутаг Оросын булаг хэмээх газар амжилттай зохион байгуулж, уралдаанд нийт 21 байгууллагын 150 | 2024.01.01-2024.12-15 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | орчим албан хаагчид оролцож мэргэжлийн ур чадвараа сорьж, туршлага мэдээлэл солилцов.<br>ҮГА-наас ойнд зориулсан эрдэм шинжилгээний бага хурал, баярын хурал, спортын өдөрлөг зэрэг арга хэмжээг 2024 оны 10 дугаар сарын 17-18-ын өдрүүдэд амжилттай зохион байгуулав. Хурлын арга хэмжээний хөтөлбөрийн дагуу бүх үйл ажиллагааны зохион байгуулалт, холбогдох санхүүжилтийг хариуцсан ажиллав. Геологийн салбарт олон жил үр бүтээлтэй ажилласан салбарын ахмад геологич, алба хаагчдад төрийн дээд одон медальд дэвшүүлэх мэдээллүүдийг нэгтгэн авч,УУХҮЯ-д хүргүүлэв. Геологи эрдэс баялагийн салбарт ажиллаж байгаа 28 хүний материалыг холбогдох журмын дагуу бүрдүүлж хүргүүлсэн байна. | | |
| 7 | 5.1.7 | Дэлхийн геологийн конгресс-2024-тэй уялдуулан хээрийн ажил зохион байгуулна. | Зохион байгуулсан эсэх:<br>0-Үгүй<br>1-Тийм | 0 | 1 | Дэлхийн геологийн конгресс-2024 /IGC2024/ ийн хүрээнд Монгол Улсад явагдах хээрийн судалгааны ажилд оролцох хүсэлтээ Post-Congress Field Trip - IGC 2024 (micehub.com) вэб хаягаар илгээж баталгаажуулах ажлыг зохион байгууллаа.<br>ҮГА Олон улсын геологийн 37 дугаар конгрессын зохион байгуулах хороотой байгуулсан санамж бичгийн хүрээнд геологийн хувьд сонирхолтой өвөрмөц тогтоц бүхий Адаацагийн офиолит-Дэмчогийн хийд-Ханбогдын шүлтлэг боржингийн массив-Шар цав-Байшин цав-Дэл уул-Цагаан суварга гэсэн маршрутын дагуу Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд, Манлай сумд болон Дундговь аймгийн Өлзийт сумдын нутаг дэвсгэрт хээрийн аяллыг 08-р сарын 31-ээс 09-р сарын 04-ний өдрүүдэд амжилттай зохион байгуулж олон улсын геологчдод МУ-ын геологи судалгааны өнөөгийн байдал, хэтийн төлвийг сурталчилан ажиллав.<br>Уг арга хэмжээнд гадны 5 судлаач эрдэмтэд оролцсон. | 2024.01.01-2024.12-15 | 100% |
| 8 | 5.1.8 | Жендэрийн мэдрэмжтэй удирдлагаар хангах, сургалт зохион байгуулна. | Сургалт зохион байгуулсан эсэх<br>0-Үгүй;<br>1-Тийм | 0 | 1 | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны явц, үр дүнгийн 2023 оны мэдээг ЖҮХ-ны мэргэжилтэнд 2024.01.05-ны өдөр мэйлээр хүргүүлсэн. Албаны албан хаагчдын хүйсийн тэнцвэрт байдлын жилийн мэдээг гаргаж, УУХҮЯ-д хүргүүлсэн.<br>Жендэрийн үндэсний хорооноос 2024.03.02-нд зохион байгуулсан "Жендэрийн үндэсний сургагч багш бэлтгэх" сургалтад хамрагдсанаар албан хаагчдын хүйсийн | 2024.01.01-2024.12-15 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тэнцвэрт байдалтай холбоотой ёс зүйн харилцаа, багаар ажиллах талаарх сургалтанд хамрагдав.<br>Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуульд заасан төрийн байгууллагын хүлээх эрэгтэй, эмэгтэй хүний эрх тэгш байдлыг хангах хариуцлагын зарчим болон “Хүйсийн 60:40 гэсэн харьцаа бүхий тэнцвэрт байдлыг хангах” заалтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. ҮГА-д эрэгтэй албан хаагч 12, эмэгтэй албан хаагч 19 буюу 61:39 хүйсийн харьцаатай ажиллаж байна.<br><br>2024 оны 05 дугаар сарын 15-18-нд Өмнөговь аймгийн Даланзадгад, Ханбогд суманд зохион байгуулагдсан "Хүний нөөц, жендерийн манлайлагч, эмэгтэйчүүдийн нэгдсэн чуулга уулзалт"-д 7 албан хаагч хамрагдсан. | | |
| 9 | 5.1.9 | Албан хэрэг хөтлөлтийн стандарт, зааврын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллана. | Албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар, холбогдох журмын дагуу шийдрэлэл-тийн хувь | 0 | 92% | Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмыг ажилдаа нэвтрүүлэн, албан хаагчдын өдөр тутмын ажилд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна.<br>>2024 оны жилийн эцсийн байдлаар ҮГА-нд нийт ирсэн бичиг 1142, явсан бичиг 699, өргөдөл гомдол 23, албан бичгийн шийдвэрлэлт 97.6 хувьтай ажиллав.<br>АЕГ-ын сургалтын төлөвлөгөөнд оруулсан “Баримт бичгийн арга зүй” сэдэвт мэргэшүүлэх цахим сургалтад 2024.03.11-13-ны өдрүүдэд хамрагдсан.<br>2024 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад нэгжүүдээс санал авч байна.<br>2023 онд хөтлөгдөж дууссан баримт бичгийг стандартын дагуу хэрэг бүрдүүлж, архивд хүлээн авч байна. | 2024.01.01-2024.12-15 | 100% |
| 10 | 5.1.10 | Mining week-2024 арга хэмжээг зохион байгуулж оролцоно. | Зохион байгуулсан эсэх<br>0-Үгүй;<br>1-Тийм | 0 | 1 | Mining week-2024 арга хэмжээ 2024 оны 10 дугаар сарын 02-05-ны өдрүүдэд зохион байгуулагдав.<br><br>Эрдэс баялгийн салбарын ил тод, нээлттэй байдлыг хангах, олон талт оролцоог дэмжих зорилготой “Уул уурхайн 7 хоног-2024” чуулга уулзалт зохион байгуулах ажилд албаны бүрэлдэхүүн оролцож ажиллав. ЭБТЭЗХ-ийн дарга Н. Мөнхбилэг Чухал ашигт малтмалын талаарх геологи судалгаа сэдвээр илтгэл хэлэлцүүлсэн бөгөөд Чухал ашигт малтмалын тогтвортой хөгжил ба дэлхийн хангаа нийлүүлэлт дэх боломжууд сэдэвт хэлэлцүүлэгийг зохион байгуулав. | 2024.01.01-2024.12-15 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 11 | 5.1.11 | Гамшгаас хамгаалах бэлэн байдлын улсын үзлэгийн бэлтгэл ажлыг зохион байгуулна. | Зохион байгуулсан эсэх<br>0-Үгүй;<br>1-Тийм | 0 | 1 | Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5 дахь хэсэг, 8.4 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.6 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсэг, Хөдөлмөрийн дотоод журмын 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийг тус тус үндэслэн Геологийн судалгааны хэлтсийн гидрогеологи, геоэкологи, грунт, геотехникийн судалгаа хариуцсан мэргэжилтэн Д.Одонтуяад Үндэсний геологийн албаны Гамшгаас хамгаалах асуудлыг хавсран гүйцэтгүүлж байна. Гамшигаас хамгаалах орон тооны бус мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн болон ажилтныг томилуулах тушаалын төслийг батлуулсан. ОБЕГ-ын байранд 2024-04-27-ны өдрөөс 2024-05-03 өдрүүдэд Зудын нөхцөл байдалтай холбогдуулан зарласан өндөржүүлсэн бэлэн байдлын хугацаанд ҮГА-наас улсын онцгой комиссын шуурхай штабт төлөөлөл оролцож ажилласан.<br>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газраас салбарын мэргэжлийн байгууллага, холбоодтой хамтран "БАЙГАЛИЙН ГАМШГИЙН ЭСРЭГ БАЯЛАГ БҮТЭЭГЧИД ХАМТДАА" аяныг салбарын хэмжээнд өрнүүлсэн.<br>Аянд Үндэсний геологийн алба, Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨҮГ,Монгол геологийн холбоодын нэгдсэн зөвлөл, Монголын уул уурхайн мэргэжлийн холбоодын зөвлөл, Монголын газрын тосны бүтээгдэхүүн импортлогчдын мэргэжлийн холбоо, Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциаци, Монголын Үйлдвэрлэлийн Геологичдын Холбоо хамтран " оролцож, ҮГА-ны ажилтанууд нэг өдрийн цалингаа хандивлан ажиллав. | 2024.01.01-2024.12-15 | 100% |
| Зорилт 5.2. | Салбарын мэргэжилтэй боловсон хүчний чадавхыг дээшлүүлэх, хэрэгжилтийг зохицуулах, зохион байгуулах | | | | | | | |
| 12 | 5.2.1 | Хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх ажлыг холбогдох яам, байгууллагатай зохион байгуулах, ажилтан, албан хаагчдыг богино, дунд хугацаат | Хамрагдсан албан хаагчдын тоо | 0 | 10 | )24 онд ҮГА-наас албан хаагчид дараах сургалтад хамрагдсан. Үүнд:<br>*Танхимаар:*<br>-АТГ-ын ХАСХОМ-ын сургалт 2024.01.31 нийт 10 төрийн албан хаагч,<br>-Удирдлагын академид Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах тухай сургалт 2024.03.18-19, 1 албан хаагч, | 2024.01.01-2024.12-15 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | сургалтад жигд хамруулах ажлыг зохион байгуулна. | | | | Төрийн албан хаагчийн гүйцэтгэл, үр дүн, төрийн байгууллагын бүтээмжийг дэмжих 2024.02.26, 2 албан хаагч,<br>-Монгол бичгийн сургалт 2024.04.01-05.01, 29 албан хаагч,<br>-Төрийн албан хаагчийн хөгжил хамгаалал "Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны тухай" 2024.03.25, 2 албан хаагч,<br>-ЗГХЭГ-ын Засгийн газрын хүний нөөцийн газар "Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим систем" 2024.05.27, 5 албан хаагч,<br>-А3 сертификаттай сургалтад 6 албан хаагч.<br>ТАЗ-ийн ***цахимаар:***<br>-2024.01.28-нд зохион байгуулагдсан сургалтад 17 албан хаагч,<br>-2024.04.18-нд зохион байгуулагдсан сургалтад 15 албан хаагч,<br>-2024.05.09-нд зохион байгуулагдсан сургалтад 21 албан хаагч.<br>*Бусад цахимаар:*<br>-2024.01.10-наас нийт албан хаагчид Эйбл программын сургалтад 30 албан хаагч.<br>*Төрийн албаны мэргэжил дээшлүүлэх сургуулийн дунд хугацааны:*<br>-Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 2 албан хаагч /ЭБСТЭЗХ/,<br>-Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх сургалтад 2 албан хаагч /ТЗУХ/,<br>-Ахлах түшмэлийн сургалтад 1 албан хаагч /ТЗУХ/<br>-Эрхэлсэн түшмэлийн сургалтад 2 албан хаагч/<br>Тэргүүн түшмэлийн сургалтад 2, /нийт давхардсан тоогоор 82 албан хаагч хамрагдсан.<br><br>Хэлний мэдлэгээ дээшлүүлэх сургалт:<br>**Talk talk English сургалтын** байгууллагад нийт 5 албан хаагч хамрагдаж, шалгалтаа амжилттай өгсөн албан хаагчид дээд түвшинд шилжин суралцаж байна.<br>Хүрсэн түвшин: Албан хаагчид сурсан мэдсэнээ ажилдаа хэрэгжүүлсэн. | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 13 | 5.2.2 | Байгууллагын албан хаагчдыг ажиллах нөхцлөөр хангах, эрүүл мэндийн үзлэгт хамруулна. | | | | Нийт 32 албан хаагчийг Монгол Японы эмнэлэгт эмнэлгийн үзлэгт хамруулсан. Тус эмнэлэгтэй тооцоо хийж, гэрээний үүргийг биелүүлсэн тухай акт үйлдсэн.<br>Албан хаагчдыг дотоод шүүрлийн, хоол боловсруулах, зүрх судас зэрэг эрүүл мэндийн нарийвчилсан үзлэг шинжилгээнд хамруулан ажиллав.<br>Байгууллагын албан хаагчдыг ажиллах нөхцлөөр хангах чиглэлээр бүх албан хаагчдыг хөдөлмөр хамгаалалын хувцас хэрэглэлээр хангах, ГБТАрхивын зарим тоног төхөөрөмжийг нүүлгэн шилжүүлж ажлын байрны зохион байгуулалтыг сайжруулах, байгууллагын архивын тоног төхөөрөмжийг худалдан авах зэрэг ажлыг гүйцэтгэсэн | 2024.01.01-2024.12-15 | 100% |
| Зорилт 5.3. Стратеги төлөвлөгөөний 5 дугаар зорилго, зорилт 2: Салбарын хууль, эрх зүйн орчны харилцааг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх | | | | | | | | |
| 14 | 5.3.2 | Геологи судалгааны чиглэлээрх холбогдох дүрэм журмыг боловсронгуй болгох, хэрэгжилтэд хяналт тавина. | Холбогдох бичиг баримт боловсронгуй болгох ажлыг зохион байгуулсан байна.<br>0-Үгүй<br>1-Тийм | 0 | 1 | Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулж батлуулах ажлыг зохион байгуулсан. ҮГА-ны даргын 2024 оны 2 дугаар сарын 16-ны А/04 тушаалаар Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн баталсан болно.<br><br>Төрийн захиргааны байгууллагын төрийн үйлчилгээний албан хаагчдад мэргэшсэн мэргэшлийн зэргийн болон ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг МУ-ын ЗГ-ын холбогдох тогтоолд нийцүүлэн зохицуулах ажлын хүрээнд Төрийн үйлчилгээний албан хаагчдад нэмэгдэл олгох 2 төрлийн журмын төслийг шинээр боловсруулж удирдах дээд байгууллагад хүргүүлэв: Үүнд: МУ-ын ЗГ-ын 2018 оны 382 дугаар тогтоолын дагуу "Геологи уул, уурхайн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох журам", "Геологи, уул уурхай салбарын төрийн үйлчилгээний албан хаагчдын мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох журам"-ын төслүүдийг УУХҮЯ-ны ТНБД-д 2024-6-5-ны өдрийн 1/357 тоот албан бичгээр хүргүүлсэн. | 2024.01.01-2024.12-15 | 70% |
| 15 | 5.3.3 | Геологийн салбарт баримтлах дунд хугацаа /2024-2034/-ны хөгжлийн зорилтот хөтөлбөр боловсруулна. | Холбогдох бичиг баримт боловсруулагд сан байна.<br>0-Үгүй | 0 | 1 | Тус алба нь 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр 1/41 тоот албан бичгээр "Геологийн салбарт баримтлах дунд хугацаа /2024-2034/-ны хөгжлийн зорилтот хөтөлбөр"-ийг хамтран боловсруулах санлыг Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн.<br>Монгол Улсын Их хурлаас 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдөр Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай, | | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 1-Тийм | | | Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлаж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам болгон өөрчилсөн. Үүнтэй холбогдуулан яамны шинэ бүтэц, зохион байгуулалт, зорилго, зорилтод түвшинтэй уялдуулах зорилгоор яамнаас чиглэл авч ажиллаж байна. | | |
| Зорилт 5.4. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлын төсвийн гүйцэтгэлд хяналт тавих /Төсөв хуваарилах, зарцуулах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах эрхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн А/06 дугаар тушаал/. | | | | | | | | |
| 16 | 5.4.1 | Байгууллагын санхүүгийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр гаргаж, хагас болон бүтэн жилээр санхүүгийн тайлан гаргаж, харьяалах байгууллагаар баталгаажуулж, УУХҮЯ, ҮАГ-т хүргүүлнэ. | Хүргүүлсэн тоо | 0 | 2 | Уул уурхай хүнд үйлдвэрийн сайд 2022 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн А/06 дугаар тушаалаар улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажилд зарцуулах төсвийн эрхийг шилжүүлсэнтэй холбогдуулан Геологийн судалгааны төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн ажлын гүйцэтгэлийг "Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам"-д нийцүүлэн 1-10 сарын буюу гүйцэтгэлийн мэдээг 10 удаа хянаж нэгтгэн, гүйцэтгэлийн мэдээг, УУХҮЯ болон ҮСХороонд хүргүүлж ажиллав.<br>УУХҮ-ийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн А/379 тоот тушаалаар Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд гүйцэтгэх нийт 23 төслийн 40,000.0 сая төгрөг баталсан. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж буй геологи судалгааны ажлын төсвийг 1-р сард 18 төслийн 452.6 сая төгрөг, 2-р сард 19 төслийн 450.5 сая төгрөг, 3-р сард 22 төслийн 654.6 сая төгрөг, 4-р сард 22 төслийн 646.6 сая төгрөг, 5-р сард 22 төслийн 1.8 тэрбум 6-р сард 19 төслийн 1,2 тэрбум төгрөг,7-р сард 18 төслийн 1,3 тэрбум төгрөг, 8-р сард 21 төслийн 937,4 сая төгрөг, 9-р сард 21 төслийн 1,0 тэрбум төгрөг, 10-р сард 23 төслийн 8,5 тэрбум төгрөгийн гүйцэтгэлийг хүлээн авсан байна. Үүнээс агаарын геофизик-2024 тендер зарлагдаж ажил эхэлсэн. 2024 оны 10 дугаар сарын байдлаар 23 төслийн нийт 23,9 тэрбум төгрөгийн гүйцэтгэлийг хүлээн авч 14.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.<br>Төрийн сан /Геологийн байгууллагын санхүүжилт-100900018019/, /Үндэсний геологийн алба ХОТХяналт-100900018371/, /Үндэсний геологийн алба барьцаа-100900018352/, /10090001853- Үндэсний геологийн алба ТЗ барьцаа/ тоот данснуудаар гүйлгээний эрхийг нээлгэж | 2024.01.01-2024.12-15 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 23 төслийн гүйцэтгэлийг сар бүр хянаж 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн Уул уурхай хүнд үйлдвэрийн сайдын "Журам шинэчлэн батлах тухай" А/87 тушаалын дагуу 2024 оны 1,2,3,4,5,6,7,8,9,10 дугаар сарын гүйцэтгэлээр санхүүжилтийн тайланг Сангийн яаманд цаг хугацаанд нь хүргүүлэн ажиллав.<br>Тайлант хугацаанд 1-11-р сарын гүйцэтгэлээр 23,4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 23 төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжид олгосон. **2024 оны 12** сард багтаж тайлант хугацааны нийт 1,6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгоно. | | |
| 17 | 5.4.2 | ҮАГ-т 2023 оны ҮГА-ны санхүүгийн тайлан хүргүүлж, хянуулна. | Хянуулсан тоо | 0 | 12 | ҮГА-ны 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2024 оны 1 дүгээр сарын 25 ны өдрийн 1/74 тоот албан бичгээр хүргүүлж тус газраас хийсэн хяналтын үр дүнд дүгээр "зөрчилгүй" дүгнэлт авсан.<br>Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартад заасны дагуу байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэлийг хөтөлж 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг гаргаж АУЭБЯ-нд хүргүүлэхэд бэлэн болсон. 2024 оны эхний хагас жилийн тайланд ҮАГ-аас санхүүгийн завсрын аудитын хяналт шалгалт хийгдэж байна. | 2024.01.01-2024.12-15 | 100% |
| 18 | 5.4.3 | Батлагдсан санхүүжилтийн хуваарийн дагуу сар бүр улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж буй геологийн судалгааны ажлын төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж, санхүүжүүлж, тайлагнана. | Төслийн тоо | 0 | 23 | УУХҮ-ийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн А/379 тоот тушаалаар Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд гүйцэтгэх нийт 23 төслийн 40.0 тэрбум төгрөг баталсан. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж буй геологи судалгааны ажлын төсвийг 1-р сард 18 төслийн 452.6 сая төгрөг, 2-р сард 19 төслийн 450.5 сая төгрөг, 3-р сард 22 төслийн 654.6 сая төгрөг, 4-р сард 22 төслийн 646.6 сая төгрөг, 5-р сард 22 төслийн 1.8 тэрбум 6-р сард 19 төслийн 1,2 тэрбум төгрөг, 7-р сард 18 төслийн 1,3 тэрбум төгрөг, 8-р сард 21 төслийн 937,4 сая төгрөг, 9-р сард 21 төслийн 1,0 тэрбум төгрөг, 10-р сард 23 төслийн 8,5 тэрбум төгрөгийн гүйцэтгэлийг хүлээн авсан байна төгрөгийн гүйцэтгэлийг хүлээн авсан байна. Үүнээс агаарын геофизик-2024 тендер зарлаж, ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллаж 10 сарын байдлаар нийт 15,1 тэрбум төгрөгийн гүйцэтгэлийг хүлээн авсан байна эхлээд байна. | 2024.01.01-2024.12-15 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 19 | 5.4.4 | Батлагдсан төлөвлөгөөний дагуу аргачлал хяналтын зардлын төсвийг шинэчлэн батлуулна. | Санхүүжүүлсэн төсвийн хэмжээ /сая.төг/ | 0 | - | Үндэсний геологийн албаны даргын 2024 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн А/07 дугаар тушаалаар Геологийн судалгааны ажлын 2024 оны аргачлал хяналтын зардлын төлөвлөгөө, төсвийг баталсан. | 2024.01.01-2024.12-15 | 100% |
| 20 | 5.4.5 | Геологийн судалгааны ажлын төсвийн зарцуулалтыг тайлагнана. | Тайлагнасан эсэх:<br>0-Үгүй<br>1-Тийм | 0 | 1 | Геологийн судалгааны ажлын ерөнхий төлөвлөгөөг 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/379 дүгээр сайдын тушаалаар баталсан бөгөөд 10 дугаар сарын байдлаар нийт 23 төслийн нийт 23.9 тэрбум төгрөгийн гүйцэтгэлийг хүлээн авч 14.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. | 2024.01.01-2024.12-15 | 100% |
| 21 | 5.4.6 | Геологийн судалгааны ажлын аргачлал хяналтын зардлыг батлагдсан төсөв, хуульд нийцүүлэн худалдан авалт хийнэ. | Худалдан авалтыг хийсэн эсэх:<br>0-Үгүй<br>1-Тийм | 0 | 1 | Үндэсний геологийн албаны даргын 2024 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн А/07 дугаар тушаалаар Геологийн судалгааны ажлын 2024 оны аргачлал хяналтын зардлын төлөвлөгөө, төсвийг баталж, уг батлагдсан төсөвт нийцүүлэн бүтэн жилийн байдлаар 560,0 сая төгрөгийн худалдан авалтыг зохион байгуулж ажиллав. Худалдан авалтын нийт 14 гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг хангуулан, гэрээний биелэлтийн актыг гэрээлэгч талтай үйлдэж, хүлээн авч баталгаажуулсан баримтын дагуу УУХҮЯ-ны Санхүүгийн хэлтсээр хянуулан, худалдан авалтыг зохион байгуулсан. | 2024.01.01-2024.12-15 | 100% |
| 22 | 5.4.7 | Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцүүлэн төсвийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах, худалдан авалтын төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтийг тайлагнана. | Хуулийн хүрээнд зохион байгуулсан эсэх:<br>0 – Үгүй<br>1–Тийм | 0 | 1 | Байгууллагын 2024 оны худалдан авах ерөнхий төлөвлөгөөг 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А/344 дүгээр тушаалаар батлуулсан. 2024 онд Харуул хамгаалалтын ажил үйлчилгээ үзүүлэх тухай тендерийг харьцуулалтын аргаар зарлаж "Шүтээн уул" ХХК, Мэдээлэл технологийн үйлчилгээ тендерийг харьцуулалтын аргаар зарлаж "Арвис системс ХХК, багаж техник хэрэгсэл тендерийг харьцуулалтын аргаар зарлаж "Ай Ти Зон" ХХК шалгарсан. Бичиг хэргийн материал худалдан авах тендер амжилтгүй болж цуцлагдсан бөгөөд шууд худалдан авалт хийж байна..<br>Мөн 2024 онд гүйцэтгэхээр төсөвт тусгагдсан ҮГА-ны байрны дээврийн засвар, ариун цэврийн өрөөнүүдийн засвар, барилгын дотоод засварын ажил үйлчилгээг худалдан авах ажиллагааг зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Эдгээр ажлуудыг ажлын | 2024.01.01-2024.12-15 | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | даалгаварыг боловсруулахдаа тухайн хийж гүйцэтгэх ажлын зураг, төсвийг эхлэн боловсруулж, холбогдох эрх бүхий *төсөвчинтэй гэрээ байгуулж*, ажил үйлчилгээний *төсөв* болон түүнтэй холбогдох бусад тооцоо судалгааг гаргаж багц хэд хэдэн удаа зарлаж амжилтгүй болж дахин тендер зарлаад байна. | | |
| 5.5 Төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлэх | | | | | | | | |
| 23 | 5.5.1 | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсөв, санхүүтэй холбогдолтой төлөвлөгөө, тайлан болон 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлого, зарлагын гүйлгээний мэдээллийг олон нийтэд нээлттэй мэдээлнэ. | Мэдээлэл байршуул-сан сарын тоо | 0 | 12 | Үндэсний геологийн албаны 2024 оны хагас жилийн эцсийн байдлаарх санхүүгийн мэдээллийг шилэн дансанд хуулийн хугацаанд байршуулан ажилласан. Үүнд: Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх Геологи судалгааны ажлын санхүүжилт, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын гүйлгээ, тайлан, аудитлагдсан тайлан, аудитын гэрчилгээ, акт, албан шаардлага, бусад мэдээлэл багтаж байна.<br>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг дараах байдлаар тайлагнаж байна. Үүнд:<br>-Төсөв, санхүүтэй холбогдолтой төлөвлөгөө, тайлан,<br>-5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлого, зарлагын гүйлгээний мэдээллийг цаг хугацаанд нь олон нийтэд нээлттэй мэдээлсэн.<br>-Байгууллагын бүтэц, орон тооны мэдээллийг шилэн дансанд 2024 оны 1 дүгээр сараас сар бүр шинэчлэн оруулж ажиллав.<br>-Байгууллагын цахим хуудсанд хагас жилийн байдлаар салбарын үйл ажиллагаатай холбоотой 14 мэдээ, мэдээллийг байршуулсан.<br>Шилэн дансны 2024 оны 1, 2 дугаар улирлын тайланг гаргаж, хуулийн хугацаанд УУХҮЯ-ны Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын газарт хүргүүлсэн.<br>Байгууллагын мэдээлэл, лавлагааны 70181208 дугаарын утсанд ирж буй дуудлагад тогтмол хариу мэдээлэл, лавлагаа өгч, холбогдох ажилтнуудад дуудлагыг шилжүүлэн, хяналт тавьсан. | 2024.01.01-2024.12-15 | 100% |
| 24 | 5.5.2 | Төсвийн орлого болон зарлагын хэмжээ, хөрөнгө оруулалтыг тооцон, 2023 оны төсвийн тодотгол, 2024 оны төсвийн хүрээний | Төсвийн төсөөлөл хүргүүлсэн эсэх:<br>0-Үгүй;<br>1-Тийм | 0 | 1 | -Үндэсний геологийн албаны 2025 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал, 2025-2026 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөөллийг боловсруулан, 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 1/312 дугаар албан бичгээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлсэн. | 2024.01.01-2024.12-15 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийг боловсруулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ. | | | | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналыг Сангийн яамны хөрөнгө оруулалтын программ http://pimis.e-nation.mn/-д оруулсан.<br><br>Улсын төсөвт 2024 оны 11 дүгээр сарын байдлаар 279,2 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 2024 онд төвлөрүүлэх орлогоо давуулан биелүүлсэн. | | |
| 25 | 5.5.3 | Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж буй нийт геологийн судалгааны ажлын сар бүрийн төсвийн гүйцэтгэл, зарцуулалтын мэдээ болон улирал бүрийн тайланг бэлтгэн, Үндэсний статистикийн хороо, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд тогтоосон хугацаанд хүргүүлнэ. | Хүргүүлсэн мэдээ, тайлан тоо | 0 | 16 | Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж буй нийт геологийн судалгааны ажлын тайланг тогтоосон хугацаанд хүргүүлсэн. Үүнд:<br>Үндэсний статистикийн хороонд: 2024/01/05 №2/20, 2024/02/02 №2/93, 2024/03/05 №1/156, 2024/04/05 №4/223, 2024/05/07 №4/290, 2024/06/06 №4/358, 2024/06/27 №4/408, 2024/07/05 №3/483, 2024/08/05 №3/483, 2024/09/02 №4/536, 2024/10/01 №1/594, 2024/11/01 №4/653,<br>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд: 2024/02/02 №1/91, 2024/03/05 №1/155, 2024/04/05 №1/219, 2024/05/07 №1/288, 2024/06/06 №1/361, 2024/06/27 №1/418, 2024/08/01 №1/479, Аж үйлдвэр эрдэс баялагийн яаманд: 2024/09/02 №1/535, 2024/10/01 №1/593, 2024/11/01 №1/650<br>Сангийн яаманд: 2024/02/02 №1/92, 2024/03/05 №1/154, 2024/04/05 №1/218, 2024/05/07 №1/287, 2024/06/06 №1/360, 2024/6/27 №1/417, 2024/08/01 №1/480, 2024/09/02 №1/534, 2024/10/01 №1/592, 2024/11/01 №1/651 дугаар албан бичгүүдээр геологийн судалгааны ажлын сар бүрийн төсвийн төсвийн гүйцэтгэл, зарцуулалтын мэдээ болон улирал бүрийн тайланг хүргүүлсэн. | 2024.01.01-2024.12-15 | 100% |
| 26 | 5.5.4 | Архивын байгуулах тоног төхөөрөмжийн судалгаа гаргах, хадгалах нөхцлийг бүрдүүлнэ. | Танилцуулсан эсэх 0-Үгүй; 1-Тийм | 0 | 1 | Архивын баримтын хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангах, архивын баримтыг зориулалтын байранд стандартын дагуу хадгалах нөхцөл бүрдүүлэх зорилгоор байгуулагдсан ажлын хэсгийн ажлууд хийгдэж, Лүндээ очир ХХК-тай гэрээ хийж 8 ш нягтруулсан шүүгээ суурилуулан, ХН-ийг хүлээн авахад бэлэн болсон.<br>Архивын баримтын хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангах, архивын баримтыг зориулалтын байранд стандартын дагуу хадгалах нөхцөл бүрдүүлж байгаа бөгөөд 2020-2023 оны архивын хавтаст баримтыг тавиур | 2024.01.01-2024.12-15 | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шүүгээнд байрлуулж, шүүгээний заагуур болон данс бүртгэлийг хийж байна. | | |
| Зорилт 5.6. Байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх санал боловсруулах, тайлагнах, хариуцлага тооцох, урамшуулах, дотоодын хяналтын тогтолцоог сайжруулах, 2025 оны зорилтот түвшин, хүрсэн түвшний зөрүүг бууруулах | | | | | | | | |
| 27 | 5.6.1 | Байгууллагын 2024 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг тогтоосон хугацаанд тайлагнана. | Төлөвлөгөө, тайлангийн тоо | 0 | 3 | Төсвийн шууд захирагчийн 2024 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2024 оны 01 дүгээр сарын 08-ний өдрийн 1/28 дугаар албан бичгээр Төсвийн ерөнхийлөн захирагчаар хянуулж, батлуулахаар хүргүүлсэн.<br>-Төсвийн шууд захирагчийн 2024 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөө Төсвийн ерөнхийлөн захирагчаар батлагдаж, 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 1/232 дугаар албан бичгээр ҮГА-нд ирсэн.<br>-Засгийн газрын баталсан Хяналт шинжилгээ, үнэлгээний журмын хүрээнд Үндэсний геологийн албаны 2024 оны хагас жилийн гүйцэтгэлийн тайланг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад 2024 оны 06 дугаар сард УУХҮ-ийн сайдад хүргүүлсэн.<br>-Нийт 83 ажил арга хэмжээ төлөвлөсөн ба, эхний хагас жилд 70 арга хэмжээний хэрэгжилтийг бүрэн тайлагнасан. 13 арга хэмжээг III-IV дүгээр улиралд төлөвлөсний дагуу хэрэгжилтийг хангаж тайлагнав.<br>Хүрсэн түвшин: Тогтоосон хугацаанд батлуулсан ба тайлагнасан. | 2024.01.01-2024.12-15 | 90% |
| 28 | 5.6.2 | Байгууллагын салбарын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг байгууллагын удирдлагад танилцуулах, хяналтад авах, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд тайлагнана. | Засгийн газрын тогтоолоор батлагдсан журмаар, хүргүүлсэн тайлангийн тоо | 0 | 2 | -УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн хуралдаанаар "журам маягт шинэчлэн батлах тухай" 5 дугаар тогтоол батлагдаж, Төрийн албан хаагчдын хөрөнгө оруулгын мэдүүлгийг бүрдүүлэхтэй холбоотой журам, маягт, жагсаалт батлагдсан. Үүнтэй холбогдуулан АТГ-аас зарласан сургалтад холбогдох ажилтныг хамруулж, мэдээллийг албаны олон нийт хэсэгт мэдээлж ажиллав.<br>-УИХ-ын 2007 оны 27 дугаар тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэгт ҮГА-наас ЭБТЭЗХ-ийн дарга Н.Мөнхбилэг ажиллаж байна.<br>-МУ-ын ЗГ-ын Төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай 2024 оны 128 дугаар тогтоолын дагуу -Төрийн албаны хүний нөөцийн программ шинэчлэгдсэнтэй холбогдуулан мэдээллийг шинэчлэх ажлыг гүйцэтгэв.<br>-МУ-ын ЗГ-ын 2024 оны 5 дугаар сарын 08-ны өдрийн 198 дугаар тогтоолын дагуу Засгийн газрын хүний нөөцийн | 2024.01.01-2024.12-15 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бодлогыг дэмжих цахим систем-ийг хэрэглээнд нэвтрүүлэх шийдвэр гарсны дагуу ҮГА-ны төрийн албан хаагчдын мэдээллийг уг системд үнэн зөв, бүрэн гүйцэт мэдээлэх ажлыг гүйцэтгэсэн.<br>-МУ-ын ЗГ-ын 2024 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолоор Мал аж ахуйн салбарт үүсээд буй нөхцөл байдал, хаваржилтын хүндрэлийг хохирол багатай даван туулах зорилгоор "Малчдадаа тусалъя аян"-ыг үндэсний хэмжээнд зохион байгуулах ажлын хүрээнд УУХҮЯ, Улаан загалмайн нийгэмлэг хамтран санаачилсан /Байгалийн гамшгийн эсрэг баялаг бүтээгчид хамтдаа" аянд УТХ-өөр геологийн судалгааны ажил гүйцэтгэгч ААН-үүдийг уриалсан. ҮГА-ны албан хаагчид улаан загалмайн нийгэмлэгийн дансанд 1 албан хаагчийн 1 өдрийн цалинг хандивлаж, албаны даргын тушаалаар баталгаажуулсан. | | |
| 29 | 5.6.3 | Алсын хараа-2050, Шинэ сэргээлтийн бодлого 2022-2025, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн арга хэмжээний төлөвлөгөө, Монгол Улсын жилийн хөгжлийн төлөвлөгөө, хөтөлбөр төслүүдийг тайлагнах, тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлнэ. | Засгийн газрын тогтоолоор батлагдсан журмаар, хүргүүлсэн тайлангийн тоо | 0 | 8 | Үндэсний геологийн албаны хариуцан хэрэгжүүлэхээр тусгагдсан дараах бодлогын баримт бичгүүдийн арга хэмжээний 2024 оны хэрэгжилтийн явцыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны холбогдох албан хаагчид, Геологийн бодлогын газарт тогтмол цахим хэлбэрээр хүргүүлсэн. Үүнд:<br>-Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр,<br>-Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөө.<br>“Тэрбум мод Үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд Налайх дүүргийн цэцэрлэгт хүрээлэнд албан байгууллагаараа Мод тарих аянд нэгдэн ажиллав. | 2024.01.01-2024.12-15 | 100% |
| 30 | 5.6.4 | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалын хэрэгжилтийг хангах, биелэлтэд хяналт | Дээд газраас ирүүлсэн чиглэлийн дагуу хүргүүлсэн | 0 | 4 | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалын биелэлтүүдэд хяналт хийгдсэн. Холбогдох мэдээллийг тухай бүр хүргүүлсэн. | 2024.01.01-2024.12-15 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | шинжилгээ үнэлгээ хийж, хүргүүлэх | тайлангийн тоо | | | | | |
| 31 | 5.6.5 | “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын дагуу албан хаагчийн гүйцэтгэлийн тайланд үнэлгээ хийж, нэгтгэх, үнэлгээний багаар хянан, баталгаажуулна. | ЗГ-ын тогтоол, ЗГХЭГ-ын даргын тушаалын дагуу үнэлгээний багийн хэрэгжүүлсэн ажлын тоо | 0 | 2 | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалын биелэлтүүдэд хяналт хийгдсэн. Холбогдох мэдээллийг тухай бүр хүргүүлсэн.<br>УУХҮЯ-ны Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2024-01-19 өдрийн 3 дугаар тогтоолын дагуу нэр бүхий 2 албан хаагчийг төрийн жинхэнэ албан хаагчаар томилсон шийдвэр гаргав. /Н.Тамир, М. Байгалмаа/.<br>-УУХҮЯ-ны Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2024-04-18 өдрийн 9 дүгээр тогтоолын дагуу нэр бүхий 1 албан хаагчийг төрийн жинхэнэ албан хаагчаар томилсон шийдвэр гаргав. /Б. Ивээл/<br>АҮЭБЯ-нд албаны төрийн албан хаагчдын зэрэг дэв ахиулах хүсэлтийг цаг хугацаанд нь хүргүүлж ажиллав<br>Хүрсэн түвшин: ҮГА-нд ирсэн тушаал шийдвэрүүдийн хэрэгжилт хангагдсан. | 2024.01.01-2024.12-15 | 100% |
| Дундаж үнэлгээ: | | | | | | | - | |

Төлөвлөгөөг үнэлсэн: ........ЯМДаг дарга........ (албан тушаал)

Тэмдэг

Төсвийн шууд захирагч .................... (гарын үсэг) /........2024-12-12........ (огноо)

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн: ........ТЗУХэлтсийн дарга........ (албан тушаал)

Нэгжийн дарга .................... (гарын үсэг) /........2024.12.12........ (огноо)

..............................

Тайлагнасан: ........ТЗУХэлтсийн дарга........ (албан тушаал)

Нэгжийн дарга .................... (гарын үсэг) /........2024-12-10........ (огноо)

........С.Ш........

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

# ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН АЖИЛТАН Х.АРИУНБАЯРЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Үр дүнгийн үзүүлэлт | | | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **НЭГ. Гүйцэтгэлийн зорилт 5.1.1, 5.1.6.** Засгийн газрын 2005 оны Иргэдийн өргөдөл гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай 67 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах, удирдах дээд байгууллагад хүргүүлэх ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ 5.1.1.1<br>Иргэд ААН-ээс ирүүлсэн өргөдөл гомдол, хүсэлтийг албан хэрэг хөтлөлтийн журмын дагуу хүлээн авч, удирдлагад танилцуулан, шийдвэрлэхтэй холбогдсон хэрэгжилтийг хангах, хэрэгжилтэд хяналт тавих, удирдах дээд байгууллагад хүргүүлэх | Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа түргэн шуурхай явагдсан байх. | 0 | Байгууллагын албан хэрэг хөтлөлт нь заавар, журмын дагуу явагдсан байна. | Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээг УУХҮЯ-нд 2/231, 1/423 тоот албан бичгээр улирал бүр хүргүүлсэн байна.<br>Шийдвэрлэлтийн байдал 97,1% хувьтай байгаа бөгөөд хяналтад 2 хүсэлт байна.<br>Нийт 26 өргөдлийг ангилбал:<br><br>Боловсон хүчний чиглэлээр гаргасан хүсэлт-23, Мэдээлэл хүссэн 3 өргөдөл байна. | 2024 оны 01-р сарын 02-оос 12 дугаар сарын 31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | Арга хэмжээ 5.1.1.2 Үндэсний геологийн албаны дэргэдэх Ёс зүйн дэд хороог хуралдуулах, тайлан мэдээг удирдлагад танилцуулах, УУХҮЯ болон Ёс зүйн хороонд улирал бүр мэдээ хүргүүлэх | Удирдах албан тушаалтанд хүргүүлэх, хурлын үр дүнг танилцуулах | 0 | Хууль журамд нийцүүлэн ажилласан байх | 2024 онд Ёс зүйтэй холбоотой асуудал үүсээгүй бөгөөд Ёс зүйн хорооноос ирүүлсэн албан бичгийн дагуу ёс зүйн дэд хорооны журмыг мөрдлөг болгон дэд хорооны 2024 оны төлөвлөгөө болон тайланг 1/247, 2/401 тоот албан бичгүүдээр мэдээлсэн. Албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг танилцуулж, Ёс зүйн хорооноос явагдах сургалтад хамрагдах захиалга хүргүүлсэн. | 2024 оны 01-р сарын 02-оос 12 дугаар сарын 30 | 100% |
| 3 | Арга хэмжээ 5.1.6.1 Монгол улсад Геологийн салбар үүсэж хөгжсөний 85 жилийн ойн арга хэмжээ зохион байгуулах ажилд оролцох | Ойн арга хэмжээнд оролцсон байна | | Ойн арга хэмжээ зохион байгуулагдсан байна | Монгол Улсад Геологийн салбар үүсэж хөгжсөний 85 жилийн арга хэмжээ зохион байгуулагдаж арга хэмжээний хүрээнд АҮЭБЯ, ҮГА, МГХНЗ хамтран “Геологичдын ажил мэргэжлийн уралдаан”-ыг 09 дүгээр сарын 27-ноос 09 дүгээр сарын 30-ны өдрүүдэд Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутаг Оросын булаг хэмээх газар амжилттай зохион байгуулж, уралдаанд нийт 21 байгууллагын 150 орчим албан хаагчид оролцож мэргэжлийн ур чадвараа сорьж, туршлага мэдээлэл солилцов. ҮГА-наас эрдэм шинжилгээний бага хурал, баярын хурал, спортын өдөрлөг зэрэг арга хэмжээг 2024 оны 10 дугаар сарын 17-18-ын өдрүүдэд амжилттай зохион байгуулахад оролцов. | 2024 оны 09-р сарын 30-аас 10 дугаар сарын 20 | |
| 4 | Арга хэмжээ 5.1.7.1 Дэлхийн геологийн конгресс 2024 -тэй уялдуулан хээрийн ажил зохион байгуулах | Зохион байгуулах ажилд оролцсон байна | | Зохион байгуулагдсан байна | ҮГА Олон улсын геологийн 37 дугаар конгрессын зохион байгуулах хороотой байгуулсан санамж бичгийн хүрээнд геологийн хувьд сонирхолтой өвөрмөц тогтоц бүхий Адаацагийн офиолит-Дэмчогийн хийд-Ханбогдын шүлтлэг боржингийн массив-Шар цав-Байшин цав-Лэп уул-Цагаан суварга гэсэн | 2024 оны 08-р сарын 30-аас 09 дугаар сарын 05-ны өдрүүдэд | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | маршрутын дагуу Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд, Манлай сумд болон Дундговь аймгийн Өлзийт сумдын нутаг дэвсгэрт хээрийн аяллыг 08-р сарын 31-ээс 09-р сарын 04-ний өдрүүдэд амжилттай зохион байгуулахад оролцов. | | |
| 5 | Арга хэмжээ 5.6.1.1<br>Хэлтсийн даргатай гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, арга хэмжээний биелэлтийг хангаж, тогтоосон хугацаанд нь тайлагнах, үр дүнг үнэлж дүгнүүлэх | Гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн тайлан, үнэлгээ. | 1 | Төрийн жинхэнэ албан хаагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хагас, жилээр гарган батлуулж, дүгнүүлсэн байна. | 1.Төрийн жинхэнэ албан хаагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хагас, бүтэн жилээр боловсруулж батлуулсан.<br>2. Төрийн жинхэнэ албан хаагчийн 2024 оны хагас жилийн болон жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланг гаргаж, хэлтсийн даргаар дүгнүүлсэн. | 2024 оны 01-р сарын 02-оос 12 дугаар сарын 30 | 100% |
| 6 | Арга хэмжээ 5.1.9.1<br>Тушаалын төслийг албаны даргад танилцуулан, заавар журмын дагуу баримтжуулах, дугаарлах, хадгалах, биелэлтэд хяналт тавих | Тушаал, шийдвэрийн тоо | 0 | Байгууллагын албан хэрэг хөтлөлт нь заавар, журмын дагуу явагдсан байна. | Тайлант хугацаанд үйл ажиллагааны чиглэлээр 71 , боловсон хүчний чиглэлээр 58 , нөөц бүртгэх 78 тушаал гарч, тушаалын төслүүдийг мэргэжилтнүүдээс хүлээн авч хэвлэмэл хуудсанд буулган баталгаажуулсан. | 2024 оны 01-р сарын 02-оос 12 дугаар сарын 31 | 100% |
| 7 | Арга хэмжээ 5.1.9.2<br>Иргэд ААН-ээс ирүүлсэн албан хүсэлтийг албан хэрэг хөтлөлтийн журмын дагуу хүлээн авч, удирдлагад танилцуулан, цахим бүртгэлд оруулан цохолтын дагуу холбогдох нэгжид шилжүүлэх, шийдвэрлэлтэд хяналт тавих | Бичгийн тоо | 0 | Байгууллагын албан хэрэг хөтлөлт нь заавар, журмын дагуу явагдсан байна. | Тайлант хугацаанд дээд шатны болон ААН-ээс 1208 бичиг ирүүлсэн бөгөөд шийдвэрлэлт 97,1% тай байна.<br><br>-Иргэний хэргийн шүүхэд хянан шийдвэрлэх тухай" хуулийн дагуу МУ-ын холбогдох шүүхээс ирсэн 3-н албан бичгийн дагуу холбогдох нотлох баримтуудыг баталгаажуулан холбогдох мэргэжилтэнд хүлээлгэн өгөв.<br>-Иргэн, ААН-тэй байгуулсан 43 гэрээг дугаарлаж, хавтаст хэрэгт хадгалж, | 2024 оны 01-р сарын 02-оос 12 дугаар сарын 31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | -Үндэсний аудитын газраас хийсэн санхүүгийн болон үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтад холбогдолтой баримт бичгүүдийг цаг тухайд нь гаргаж нотлох баримтын шаардлага хангуулан хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн. | | |
| 8 | Арга хэмжээ 5.1.9.3 Байгууллагаас гадагш явуулсан бичгийг цахим төлөвлөлтөөс удирдлагаар баталгаажуулсан бичгийг хүлээн авч зөв бичих дүрэм,найруулга зүй, стандартын дагуу хэвлэмэл хуудсанд буулгах, тамга тэмдгээр баталгаажуулж, дугаар өгөх, цахим бүртгэлд оруулах, хувийг хавтсанд хийж хадгалах, явах хувийг шууданд хүлээлгэн өгөх, хяналт тавих: | Бичгийн тоо | 0 | Байгууллагын албан хэрэг хөтлөлт нь заавар, журмын дагуу явагдсан байна. | Жилийн эцсийн байдлаар албанаас гадагш явуулсан 755 бичгийг буюу 6250 хуудас материалыг бэлтгэн, хянаж баталгаажуулан шууданчид хүлээлгэн өгч, бусад хувийг хавтсанд хийж баримт үүсгэн, хяналт тавьж ажилласан байна. | 2024 оны 01-р сарын 02-оос 12 дугаар сарын 31 | |
| 9 | Арга хэмжээ 5.1.9.4 2024 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалт боловсруулах, санал авах | Санал авах, боловсруулах | 0 | Санал авч, боловсруулсан байна | 2024 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад нэгжүүдээс авсан саналыг авч хадгалах хугацааг байгууллагын БНШК-оор оруулсан. | 2024 оны 01-р сарын 02-оос 03 дугаар сарын 31 | |
| 10 | Арга хэмжээ 5.1.9.5 Хэвлэмэл хуудасны захиалга, ашиглалт, зарцуулалтыг бүртгэж, хяналт тавих, зарцуулалтын тайлан мэдээг хагас, бүтэн жилээр гаргаж тайлагнах, баримт бичгийн эргэлтийн тоо хэмжээг тооцох, судалгаа гаргах | Стандартын дагуу хэвлүүлэх, төрөлжүүлэх, бүртгэлд авах, зарцуулалтад хяналт тавих | 0 | Стандартын дагуу хийгдсэн | АЕГ-ын Улсын байцаагчаар хянуулсан хэвлэмэл хуудсуудыг ашиглаж байгаа бөгөөд жилийн эцсийн байдлаар А-4 1142, А-5 689, хурлын тэмдэглэл 6 ш, тушаалын 585 ш, тодорхойлолтын 20 ш, гадаад албан бичгийн 60 ш хэвлэмэл хуудсуудыг ашигласан бөгөөд бүртгэлд оруулан, хяналт тавьж тайлан мэдээ гарган ажиллаж байна. Баримт бичгийн эргэлтийн хэмжээ нь өмнөх онуудаас өссөн дүнтэй байна. | 2024 оны 01-р сарын 02-оос 12 дугаар сарын 30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 11 | Арга хэмжээ 5.1.9.6 БНШК хуралдуулж нэгжүүдээс авсан баримтын хадгалах хугацааны жагсаалт, цаашид авах арга хэмжээний төлөвлөгөө батлуулах | Байгууллагын архивын дүрэм заавры г мөрдөн ажиллах | 0 | Байгууллагын албан хэрэг хөтлөлт, архив нь заавар, журмын дагуу явагдсан байна. | 2024 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад 6 нэгжүүдээс авсан саналыг авч хадгалах хугацааг байгууллагын БНШК-оор оруулсан. | 2024 оны 01-р сарын 02-оос 03 дугаар сарын 30 | |
| 12 | Арга хэмжээ 5.1.9.7 Байгууллагын баримт бичгийн эргэлтийн хэмжээг тооцох, судалгаа гаргах | Баримт бичгийн эргэлтийн хувь | 0 | Байгууллагын албан хэрэг хөтлөлт, архив нь заавар, журмын дагуу явагдсан байна. | 2020-2023 оны байдлаар баримт бичгийн эргэлтийн хэмжээ 2024 онд 15 хувиар өссөн. | 2024 оны 01-р сарын 2-оос 12 дугаар сарын 31 | 100% |
| 13 | Арга хэмжээ 5.1.9.8 2024 онд хөтлөгдөж дууссан баримт бичгийг архивд ХХНЖ-ийн дагуу архивд хүлээн авахад бэлтгэх, хүлээн авах,бүртгэлжүүлэх | Байгууллагын архивын дүрэм заавры г мөрдөн ажиллах | 0 | Архивын үйл ажиллагаа хэвийн явагдсан байна. | Албаны 6 нэгжээс санал авч, саналын дагуу байгууллагын архивд хөтлөгдөж дууссан баримт бичгийг стандартын дагуу хүлээн авч бүртгэлжүүлсэн | 2024 оны 01-р сарын 02-оос 03 дугаар сарын 30 | 100% |
| 14 | Арга хэмжээ 5.1.9.9 Цахим архив үүсгэх, цахим архивын хадгалалт хамгаалалтын судалгаа гаргах, хэрэгжүүлэх | Байгууллагын архивын дүрэм заавры г мөрдөн ажиллах | | Архивын үйл ажиллагаа хэвийн явагдсан байна. | Байгууллагын архивын баримтыг цахимжуулах тоног төхөөрөмж бэлтгэсэн бөгөөд байнга хадгалах баримтуудыг скайнердаж байгаа бөгөөд цахим архивын программ нь хангалттгүй байна. | 2024 оны 01-р сарын 2-оос 12 дугаар сарын 31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 15 | Арга хэмжээ 5.1.1.5 Албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр гарсан дүрэм, журмын дагуу баримт бичиг зохион бүрдүүлэх, байгууллагын хэмжээнд мөрдүүлэх, албан хаагчдад албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн стандартын хэрэгжилтийн асуудлаар арга зүйгээр хангаж ажиллах, сургалт явуулах | Сургалтын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | 0 | Сургалтын төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтэд хяналт тавьсан байна. | Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмыг ажилдаа нэвтрүүлэн, албан хаагчдын өдөр тутмын ажилд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. | 2024 оны 01-р сарын 02-оос 12 дугаар сарын 30 | 100% |
| **Гүйцэтгэлийн зорилт 5.5.4. Байгууллагын архивын зориулалтын барилга, өрөө тасалгаанд тавигдах шаардлага, стандартад нийцүүлж, хадгаламжийн сан байгуулах.** | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ: 5.5.4.1- Байгууллагын архив байгуулах зураг төслийг боловсруулж, удирдлагад танилцуулж, тоног төхөөрөмжийн судалгаа гаргах, төсөв хөрөнгө шийдүүлэх санал боловсруулах, | Төлөвлөгөө боловсруулсан байх | 0 | Төлөвлөгөөний дагуу ажил явагдсан байна. | Архивын баримтын хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангах, архивын баримтыг зориулалтын байранд стандартын дагуу хадгалах нөхцөл бүрдүүлэх зорилгоор Албаны даргын 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/14 дүгээр тушаалаар ажлын хэсэг байгуулагдан зохих журмын дагуу ААН-ийг шалгаруулж, засвар үйлчилгээний ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд архивын нягтруулсан шүүгээг байрлуулж, бусад тоног төхөөрөмжийн захиалгыг байгууллагын удирдлагад танилцуулсан. | 2024 он 01 дүгээр сарын 15-аас -12 сарын 15 | 80% |

НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР /АРГА ХЭМЖЭЭНИЙ/ БИЕЛЭЛТ

| д/д | Үүрэг даалгавар /арга хэмжээ/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Арга хэмжээ 5.5.4-. Албаны даргад танилцуулагдах албан бичиг, тушаал шийдвэрийг цаг алдалгүй танилцуулж | | 0 | Өдөр тутмын үйл ажиллагаа тасралтгүй, тухай бүр шуурхай явагдсан байх | Даргыг өдөр тутмын мэдээллээр хангах, хурал зөвлөгөөний цаг товлох, мэргэжилтнүүдтэй холбох, уулзалт зохион байгуулах үйл ажиллагааг хэвийн явуулах, ЭБМЗ-ийн хурлын тов, шаардлагатай мэдээллүүдийг | 2024 оны 01-р сарын 02-оос 12 дугаар сарын 30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шийдвэрлүүлэх, уулзалт, хурал, зөвлөгөөнд оролцох цагийг зохицуулах, бэлтгэлийг хангах, гадаад, дотоодын байгууллага, иргэдийг авах уулзалтын цагийг зохицуулах, хүлээн авах цагийг товлох, баталгаажуулж зар хүргэх, бэлтгэлийг хангах,<br>даргын албан өрөө тасалгаанд цэвэрлэгээ үйлчилгээ хийлгэх, бичгийн хэрэгсэл, цайны болон шаардлагатай материалыг захиалан бэлтгүүлэх, уулзалтын үед цай, кофегоор үйлчлэх | Удирдлагыг мэдээллээр хангах, цаг үеийн ажлыг шуурхай зохион байгуулах | | | гаргаж өгөх, хурлын нарийн бичигт мэдээллийг цаг алдалгүй хүргэх, өрөөний цэвэрлэгээ үйлчилгээ өдөр тутамд тасралтгүй явагдаж байна.<br>2024 оны жилийн эцсийн байдлаар хуралдаан, гадны төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байгаа ААН-ийн уулзалтад бэлтгэн, шаардлагатай материал, тоног төхөөрөмжийн бэлтгэл хангаж ажилласан байна.<br>Удирдлагуудад шаардлагатай баримт материалыг нэгжүүдээс нэгтгэн хүргүүлэх, нэгжүүдэд мэдээлэх ажлууд хийгдсэн байна. | | |
| 2 | Ажлын гүйцэтгэлийг сайжруулах, цаг үеийн шинжтэй асуудлыг шийдвэрлэх зорилгоор өгч буй үүрэг даалгавар | -Нэгжийн дарга, ахлах<br>-Байгууллагын удирдлага, хурал | 0 | Цаг үеийн асуудлыг бүрэн цаг хугацаанд нь бүрэн шийдвэрлэсэн байна. | 1. Байгууллагын гадна талбайн мод тайрах хэлбэржүүлэх, цэвэрлэгээ үйлчилгээний ажилд гар бие оролцсон.<br>2. Албатай холбоотой зохион байгуулагдах үйл ажиллагаа болон удирдлагын үүрэг даалгаврын дагуу хурал зөвлөгөөнд оролцсон.<br>УУХҮЯ, ГШТөв, АМГТГ, Эрчис ойл ХХК, ҮГА-тай хамтарсан нөхөрсөг спортын арга хэмжээнд оролцсон.<br>3.Албатай холбоотой зохион байгуулагдах үйл ажиллагаа болон удирдлагын үүрэг даалгаврын дагуу хурал зөвлөгөөнд оролцсон.<br>4. Өмнөговь аймагт 2024.04.28-29-ний өдрүүдэд зохион байгуулагдсан "Эрдэс баялгийн салбарын эмэгтэйчүүд"-ийн 4-р чуулга уулзалтад амжилттай | 2024 оны 01-р сарын 02-оос 12 дугаар сарын 31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 5.“Тэрбум мод” үндэсний хөтөлбөрт оролцсон. | | |

## ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Гүйцэтгэлийн түвшин | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Шалгуур үзүүлэлт | суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэл-тийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Арга хэмжээ 2.1<br>Архив албан хэрэг хөтлөлтийн болон бусад байгууллагаас зохион байгуулсан сургалтад тухай бүр хамрагдах | Богино хугацааны сургалтын хөтөлбөрт харагдсан байна. | 0 | Мэдлэг авсан байна | - ЦХХХЯ, Е-монголиа академи УТҮГ, АЕГ-ын хамтран зохион байгуулсан “Төрийн албан хаагчдад цахимаар албан бичиг солилцох талаар сургалтад хамрагдсан.<br>- АЕГ-ын сургалытын төлөвлөгөөнд оруулсан “Баримт бичгийн арга зүй” сэдэвт мэргэшүүлэх цахим сургалтад 2024.03.11-13-ны өдрүүдэд хамрагдсан<br><br>- 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан “Хос бичигтэн” болох Монгол бичгийн анхан шатны сургалтыг “Чой Лувсанжавын нэрэмжит Хэл иргэншлийн эрдмийн хүрээлэн”-ийн багш Б.Амгалантай гэрээ хийн, 2024.04.01-ээс 05.06-ны өдрийг дуустал 30 цагийн сургалтад нийт 30 албан хаагч хамрагдсанаас 26 албан хаагч гэрчилгээ авч, амжилттай зохион байгууллаа. | 2024 оны 01-р сарын 02-оос 12 дугаар сарын 30 | 100% |

ТАЙЛАН ГАРГАСАН:

АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН АЖИЛТАН Х.АРИУНБАЯР

*( Албан тушаал )* *( Нэр, гарын үсэг)*

2024.12.10

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

# ДОТООД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Б.БАТЛХАГВАГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Үр дүнгийн үзүүлэлт | | | Эхэлсэн дуссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | | |
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| Зорилго 5. Төрийн захиргааны удирдлагын манлайлал, хүний нөөцийн удирдлагаар хангах, байгууллагын хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг оновчтой удирдах, тайлагнах, албаны үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам, стандарт боловсруулах, батлуулах, мөрдүүлэхэд эрх зүйн дэмжлэг үзүүлэх, салбарын хэмжээнд байгуулагдах гэрээ, хэлэлцээр хийх ажлыг зохион байгуулах, салбарыг сурталчлах, хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудлыг эрхлэх, гадаад орнууд, олон улсын геологийн алба, байгууллагатай хамтын ажиллагаа хөгжүүлэх | | | | | | | |
| Зорилт 5.3. Үндэсний геологийн албаны Стратеги төлөвлөгөөний 5 дугаар зорилго, Зорилт 2. Салбарын хууль, эрх зүйн орчны харилцааг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх | | | | | | | |
| 1 | Үндэсний геологийн албаны Стратеги төлөвлөгөөний 2025-2029 оны төсөл боловсруулах, | Төсөл боловсруулах ажлын хэсэгт ажилласан байна. | - | Төсөл боловсруулсан, ажлын хэсэгт ажилласан байна. | -Тайлант хугацаанд Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, Үндэсний геологийн албаны хэрэгжүүлэх арга хэмжээг судлан шуурхайд танилцуулсан, Стратеги төлөвлөгөөний 2025-2029 оны төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллаж байна. | 12сарын 01 12сарын 31 | 70% |
| ЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 217 дугаар тогтоол, ЗГХЭГ-ын даргын "Аргачлал загвар батлах тухай" 2020 оны 100 дугаар тушаал, 2023 оны 98 дугаар тушаал | | | | | | | |
| 2 | Арга хэмжээ 5.6.1.3. Байгууллагын 7 хоногийн мэдээ танилцуулах, | Цаг хугацаанд нь нэгтгэсэн, танилцуулсан байна. | - | 7 хоног бүр танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавьсан байна. | - Тайлант хугацаанд ҮГА-ны хэтсүүдийн тайланг 4 дэх өдөр бүр нэгтгэн, 7 хоног бүрийн нэг дэх өдрийн шуурхай дээр хэрэгжилтийн биелэлтийг танилцуулсан. | 12сарын 01 12сарын 31 | 100% |
| Зорилт 5.3. Байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх санал боловсруулах, тайлагнах, хариуцлага тооцох, урамшуулах дотоодын хяналтын тогтолцоог сайжруулж боловсронгуй болгох.<br>ЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам, ЗГ-ын Стратеги бүтцийн өөрчлөлийн хөтөлбөрийн 2.5.1.7, ҮГА-ны Стратеги төлөвлөгөө 2020-2024 -Зорилт 5.3 | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | Арга хэмжээ 5.6.2.1. Байгууллагын гүйцэтгэлийн тайланг нэгжүүдээс авч, нэгтгэн боловсруулах, удирдлагуудад хэрэгжилтийн явцын тухай танилцуулах, хэлтсүүдэд хэрэгжилтийн үр дүнг ахиулахад санал өгөх. | Цаг хугацаанд нь нэгтгэсэн, танилцуулсан , хүргүүлсэн байна. | - | АҮЭБЯ-нд хүргүүлсэн байна. | Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн тайланг нэгжүүдээс авч, нэгтгэн боловсруулж, хэрэгжилтийн явцын тухай танилцуулан хугацаанд нь АҮЭБЯ-нд хүргүүлсэн. | 12сарын 01 12сарын 31 | 100% |
| 4 | Арга хэмжээ 5.6.2.2 Хууль тогтоомж, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд батлагдсан журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Аж үйлдвэр эрдэс баялагийн яаманд хүргүүлнэ. | Тогтоосон хугацаанд тайлаг хүргүүлсэн байна. | - | АҮЭБЯ-нд хүргүүлсэн байна. | Алсын хараа 2050, "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрт үндэсний геологийн албаны хариуцан хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт, үйл ажиллагааны хэрэгжилт"-ийн тайлан, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Үндэсний геологийн Албаны хариуцан хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийн тайлан, Монгол Улсын их хурлын тогтоолоор батлагдсан "Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө"-нд Үндэсний геологийн албаны хариуцан хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийн тайлан, Үндэсний геологийн албаны хариуцан хэрэгжүүлэхээр ирүүлсэн дээд газруудын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайланг тайлант хугацаанд АҮЭБЯ-нд хүргүүлсэн. | 12сарын 01 12сарын 31 | 100% |
| 5 | Арга хэмжээ 5.6.2.3 Шинэ сэргэлтийн бодлого 2021-2025, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2021-2025 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн тухайн | Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг нэтгэсэн танилцуулсан АҮЭБЯ-нд | - | Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг нэтгэсэн танилцуулсан АҮЭБЯ-нд хүргүүлсэн байна. | Үндэсний геологийн албаны 2024 оны гүйцэтгэлийн тайланд хийсэн дотоод хяналт шинжилгээ, үнэлгээний тайланг тайлант хугацаанд АҮЭБЯ-нд хүргүүлсэн.<br>"Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрт үндэсний геологийн албаны хариуцан | 12сарын 01 12сарын 31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | жилийн төлөвлөгөөний хэрэгжилт, хөтөлбөр төслүүдийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | хүргүүлсэн байна. | | | хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт, үйл ажиллагааны хэрэгжилт"-ийн тайлан, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Үндэсний геологийн Албаны хариуцан хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийн тайлан, Монгол Улсын их хурлын тогтоолоор батлагдсан "Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө"-нд Үндэсний геологийн албаны хариуцан хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийн тайланг нэгтгэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. | | |
| 6 | Арга хэмжээ 5.6.2.4 Байгууллагын гүйцэтгэлийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмаар үнэлгээ хийсэн байна. | | Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байна. | Үндэсний геологийн албаны даргын 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн Б/69 дугаар тушаалаар Үнэлгээний багийн нарийн бичгийн даргаар ажиллаж албаны албан хаагчдын тайланд дүн шинжилгээ хийж нийт 30 албан хаагчдын тайланг удирдлагад танилцуулан үнэлүүлсэн. | 12сарын 01<br>12сарын 31 | 100% |
| "ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД<br>Зорилт 5.4. Төрийн албаны тухай хууль, Авлигын эсрэг хууль, бусад хууль тогтоомж | | | | | | | |
| 7 | Арга хэмжээ 5.6.4.2 Удирдах дээд байгууллагын удирдлагууд, даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт орж ажиллах, тушаал шийдвэрүүдийн хэрэгжилт болон удирдлага, хэлтсийн даргын өгсөн бусад үүргийн дагуу ажиллах, танилцуулна. | Хууль эрхзүйн хүрээнд цаг хугацаанд нь хэрэгжүүлсэн, танилцуулсан байна. | - | Хууль эрхзүйн хүрээнд цаг хугацаанд нь хэрэгжүүлсэн, танилцуулсан байна. | - Тайлант хугацаанд Үндэсний геологийн албаны 2024 оны Гүйцэтгийн тайлан, Бодлогын баримт бичгийн тайланг хугацаанд нь АҮЭБЯ-нд хүргүүлсэн.<br>- ҮГА-нд Үдэсний аудитын газраас ирүүлсэн бичгийн дагуу хэлтсүүдээс саналыг нь авч нэгтгэн төлөвлөгөө боловсруулан хариу албан бичгээр хүргүүлэн ажилласан.<br>- МУ-ын ЗГХЭГ-аас ирүүлсэн яаралтай албан бичгийн дагуу хүний нөөцийн шаардлагатай мэдээллүүдийг бэлтгэн хариу хүргүүлэн ажилласан.<br>- Монгол Улсын Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас ирүүлсэн 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн | 12сарын 01<br>12сарын 31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 01/1085 дугаартай албан бичигтэй бүх албан хаагчдыг судалгаанд бүрэн хамруулсан. | | |
| ХОЁР. МЭДЛЭГ, ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ" ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ 1.<br>Мэдлэг чадвараа бие дааж дээшлүүлэх,<br>-Байгууллагаас зохион байгуулж буй сургалтад хамрагдах,<br>-Авлигын эсрэг сургалт<br>-Албан хэрэг хөтлөлтийн сургалт<br>-Жендерийн мэдрэмжтэй удирдлага,<br>-Шинэчлэн батлагдах ЗГ-ын 2024-2028 оны хөтөлбөрийн танилцуулга-сургалт-хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур | Дунд болон богино хугацааны сургалтын хөтөлбөрт хамрагдах | - | Дунд болон богино хугацааны сургалтын хөтөлбөрт хамрагдсан байна | Шинээр томилогдсон, сургалтанд хамрагдах хугацаа байгаагүй. | 12сарын 01<br>12сарын 31 | |

ТАЙЛАН ГАРГАСАН:

| | | |
|---|---|---|
| Дотоод хяналт шинжилгээ,үнэлгээ хариуцсан мэргэжилтэн | Баттулгын Батхагва<br>............................ | 2024.12.31 |
| *( Албан тушаал )* | *( Овог нэр, гарын үсэг )* | *( Огноо )* |

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

# АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ Д.ДАВААДОЛГОРЫН
# 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Үр дүнгийн үзүүлэлт | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхлэсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| Зорилго 5. Төрийн захиргааны удирдлагын манлайлал, хүний нөөцийн удирдлагаар хангах, байгууллагын хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг оновчтой удирдах, тайлагнах, албаны үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам, стандарт боловсруулах, батлуулах, мөрдүүлэхэд эрх зүйн дэмжлэг үзүүлэх, салбарын хэмжээнд байгуулагдах гэрээ, хэлэлцээр хийх ажлыг зохион байгуулах, салбарыг сурталчлах, хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудлыг эрхлэх, гадаад орнууд, олон улсын геологийн алба, байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх | | | | | | | |
| Зорилт 5.1. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах /ҮГА-ны Стратеги төлөвлөгөө 5.1/ | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ 5.1.6.1 Монгол Улсад Геологийн салбар үүсэж хөгжсөний 85 жилийн арга хэмжээ зохион байгуулах ажилд оролцоно. | Хэрэгжүүлсэн ажлын тоо | 0 | 1 | Монгол Улсад Геологийн салбар үүсэж хөгжсөний 85 жилийн арга хэмжээ зохион байгуулах бэлтгэл ажлыг хангав. Ойн арга хэмжээний хүрээнд Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Үндэсний геологийн алба, Монголын Геологийн холбоодын нэгдсэн зөвлөл хамтран “Геологичдын ажил мэргэжлийн уралдаан”-ыг 09-сарын 27-ноос 09-р сарын 30-ны өдрүүдэд Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутаг Оросын булаг хэмээх газар амжилттай зохион байгуулж, уралдаанд нийт 21 байгууллагын 150 орчим албан хаагчид оролцож мэргэжлийн ур чадвараа сорьж, туршлага мэдээлэл солилцов.<br>ҮГА-наас ойнд зориулсан эрдэм шинжилгээний бага хурал, баярын хурал, спортын өдөрлөг зэрэг арга хэмжээг 2024 оны 10 дугаар сарын 17-18-ын өдрүүдэд амжилттай зохион байгуулав. Хурлын арга хэмжээний хөтөлбөрийн дагуу бүх үйл | 2024. 01-12 сар | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажиллагааны зохион байгуулалт, холбогдох санхүүжилтийг хариуцсан ажиллав. | | |
| 2 | Арга хэмжээ 5.1.7.1 Дэлхийн геологийн конгресс-2024-тэй уялдуулан хээрийн ажил зохион байгуулна. | Тийм | 0 | 1 | ийн хүрээнд Монгол Улсад явагдах хээрийн судалгааны ажилд оролцох хүсэлтээ Post-Congress Field Trip - IGC 2024 (micehub.com) вэб хаягаар илгээж баталгаажуулах ажлыг зохион байгууллаа. ҮГА Олон улсын геологийн 37 дугаар конгрессын зохион байгуулах хороотой байгуулсан санамж бичгийн хүрээнд геологийн хувьд сонирхолтой өвөрмөц тогтоц бүхий Адаацагийн офиолит-Дэмчогийн хийд-Ханбогдын шүлтлэг боржингийн массив-Шар цав-Байшин цав-Дэл уул-Цагаан суварга гэсэн маршрутын дагуу Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд, Манлай сумд болон Дундговь аймгийн Өлзийт сумдын нутаг дэвсгэрт хээрийн аяллыг 08-р сарын 31-ээс 09-р сарын 04-ний өдрүүдэд амжилттай зохион байгуулж олон улсын геологчдод МУ-ын геологи судалгааны өнөөгийн байдал, хэтийн төлвийг сурталчилан ажиллав. Уг арга хэмжээнд гадны 5 судлаач эрдэмтэд оролцсон. | 2024. 01-12 сар | 100% |
| 3 | Арга хэмжээ: 5.1.8.1 2024 оны хагас, бүтэн жилийн хөрөнгийн тооллогыг хийж үр дүнг тооцож тайлагнана. | Тийм | 0 | 2 | Байгууллагын хагас бүтэн жилийн хөрөнгийн тооллогыг А/34, А/70 тушаалын дагуу хуульд заасан хугацаанд хийж гүйцэтгэж үр дүнг тайлагнасан. Байгууллагын эд хөрөнгийн хадгалалт хамгаалалт, бүртгэлийг тухай бүрд нь хийж, цаашид ашиглах боломжгүй эд хөрөнгийг акталж бүртгэлээс хассан. Үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн мэдээг ТӨБЗГазарт албан бичгээр хүргэж байсан. 2023 оны Төрийн өмч эзэмших гэрээг 86%-тай дүгнүүлж хангалттай үнэлгээ авч 2024 оны гэрээг ТӨБЗГазартай байгуулсан. Хөрөнгөтэй | 2024-06,12 сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | холбоотой бичиг баримтуудыг бүрэн гүйцэд хийж гүйцэтгэсэн. ТӨБЗГ-аас өгсөн заавар зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаж байна. | | |
| Зорилт 5.2. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлын төсвийн гүйцэтгэлд хяналт тавих /Төсөв хуваарилах, зарцуулах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах эрхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн А/06 дугаар тушаал/. | | | | | | | |
| 4 | Арга хэмжээ 5.2.1.1 Байгууллагын санхүүгийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр гаргаж, хагас болон бүтэн жилээр санхүүгийн тайлан гаргаж, харьялах байгууллагаар баталгаажуулж, АҮЭБЯ, ҮАГ-т хүргүүлнэ. | 12 | 0 | 12 | ҮГА-ны 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2024 оны 1 дүгээр сарын 25 ны өдрийн 1/74 тоот албан бичгээр хүргүүлж тус газраас хийсэн хяналтын үр дүнд дүгээр “зөрчилгүй” дүгнэлт авсан.<br>Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,Төсвийн тухай хууль, Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартад заасны дагуу байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэлийг хөтөлж 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг гаргаж УУХҮЯ-нд хүргүүлсэн. 2024 оны эхний хагас жилийн тайланд ҮАГ-аас завсрын аудит орсон. Шалгалтын дүн сүүлийн хагас жилийн тайлангийн үр дүнг шалгасаны дараа гархаар хүлээгдэж байна. | 2024. 01-12 сар | 100% |
| 5 | Арга хэмжээ 5.2.2.1 НД, ХАОАТТ тайланг сар, улирлаар гаргаж, харьяа дүүргийн НД, Татварын хэлтэст хүргүүлнэ. | 12 | 0 | 12 | Нягтлан бодох бүртгэл, Төсвийн тухай хуулийн дагуу ҮГА-н НДШ-ийн тайланг сар бүрийн 5-ны дотор, ХХОАТатварын тайланг дараа сарын 10-ны дотор гаргаж СХД-ийн НДХэлтэс болон СХД-ийн Татварын хэлтэст илгээж баталгаажуулж ажиллаж байна.<br>ТӨБЗГ-тай хийсэн 2023 оны Төрийн өмч эзэмшүүлэх гэрээний биелэлтийг амжилттай дүгнүүлж 2024 оны гэрээг байгуулж ажиллаа. | 2024. 01-12 сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | Арга хэмжээ 5.2.3.1 ҮАГ-т 2023 оны санхүүгийн тайланг ҮАГ-т хүргүүлж, хянуулна. | 2 | 0 | 2 | Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,Төсвийн тухай хууль, Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартад заасны дагуу байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэлийг хөтөлж 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг гаргаж АҮЭБЯаманд хүргүүлсэн. 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд гаргаж 2025 оны 01 дүгээр сарын 25-ны дотор АҮЭБЯ,ҮАГ-т хүргүүлнэ. | 2024. 01-12 сар | 100% |
| 7 | Арга хэмжээ 5.2.4.1 Батлагдсан санхүүжилтийн хуваарийн дагуу сар бүр улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж буй геологийн судалгааны ажлын төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж, санхүүжүүлж, тайлагнана. | 25 | 0 | 25 | Уул уурхай хүнд үйлдвэрийн сайд 2022 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн А/06 дугаар тушаалаар улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажилд зарцуулах төсвийн эрхийг шилжүүлсэнтэй холбогдуулан Геологийн судалгааны төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн ажлын гүйцэтгэлийг “Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам”-д нийцүүлэн 1-5 сарын буюу гүйцэтгэлийн мэдээг 5 удаа хянаж нэгтгэн, гүйцэтгэлийн мэдээг, УУХҮЯ болон ҮСХороонд хүргүүлж ажиллав.<br>УУХҮ-ийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн А/379 тоот тушаалаар Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд гүйцэтгэх нийт 23 төслийн 40,000.0 сая төгрөг баталсан. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж буй геологи судалгааны ажлын төсвийг 1-р сард 18 төслийн 452.6 сая төгрөг, 2-р сард 19 төслийн 450.5 сая төгрөг, 3-р сард 22 төслийн 654.6 сая төгрөг, 4-р сард 22 төслийн 646.6 сая төгрөг, 5-р сард 22 төслийн 1.8 тэрбум 6-р сард 19 төслийн 1,2 тэрбум төгрөг,7-р сард 18 төслийн 1,3 тэрбум төгрөг, 8-р сард 21 төслийн 937,4 сая төгрөг, 9-р сард 21 төслийн 1,0 тэрбум төгрөг, 10-р сард 23 | 2024. 01-12 сар | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төслийн 8,5 тэрбум төгрөгийн гүйцэтгэлийг хүлээн авсан байна. Үүнээс агаарын геофизик-2024 тендер зарлагдаж ажил эхэлсэн. 2024 оны 12 дугаар сарын байдлаар 23 төслийн нийт 31,8 тэрбум төгрөгийн гүйцэтгэлийг хүлээн авч 25,5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.<br>Төрийн санд /Геологийн байгууллагын санхүүжилт-100900018019/, /Үндэсний геологийн алба ХОТХяналт-100900018371/, /Үндэсний геологийн алба барьцаа-100900018352/, /10090001853-Үндэсний геологийн алба ТЗ барьцаа/, /Үндэсний геологийн алба Нэмэлт санхүүжилт-100900018410/ тоот данснуудаар гүйлгээний эрхийг нээлгэж 23 төслийн гүйцэтгэлийг сар бүр хянаж 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн Уул уурхай хүнд үйлдвэрийн сайдын "Журам шинэчлэн батлах тухай" А/87 тушаалын дагуу 2024 оны 1,2,3,4,5,6,7,8,9,10,11,12 дугаар сарын гүйцэтгэлээр санхүүжилтийн тайланг Сангийн яаманд цаг хугацаанд нь хүргүүлэн ажиллав.<br>Тайлант хугацаанд 1-11-р сарын гүйцэтгэлээр 25,5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 23 төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжид олгосон. | | |
| 8 | Арга хэмжээ 5.2.5.1 Батлагдсан төлөвлөгөөний дагуу аргачлал хяналтын зардлын төсвийг шинэчлэн батлуулна. | 1 | 0 | 1 | Үндэсний геологийн албаны даргын 2024 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн А/07 дугаар тушаалаар Геологийн судалгааны ажлын 2024 оны аргачлал хяналтын зардлын төлөвлөгөө, төсвийг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | 2024. 01-12 сар | 90% |
| 9 | Арга хэмжээ 5.2.6.1 Геологийн судалгааны ажлын төсвийн зарцуулалтыг тайлагнана. | 2 | 0 | 2 | Уул уурхай хүнд үйлдвэрийн сайд 2022 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн А/06 дугаар тушаалаар улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажилд | 2024. 01-12 сар | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зарцуулах төсвийн эрхийг шилжүүлсэнтэй холбогдуулан Геологийн судалгааны төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн ажлын гүйцэтгэлийг “Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам”-д нийцүүлэн 1-11 сарын буюу гүйцэтгэлийн мэдээг 11 удаа хянаж нэгтгэн, гүйцэтгэлийн мэдээг АҮЭБЯаманд хүргүүлж ажиллав.<br>Төрийн сан /Геологийн байгууллагын санхүүжилт-100900018019/, /Үндэсний геологийн алба ХОТХяналт-100900018371/, /Үндэсний геологийн алба барьцаа-100900018352/, /10090001853-Үндэсний геологийн алба ТЗ барьцаа/ /Үндэсний геологийн алба Нэмэлт санхүүжилт-100900018410 /,тоот дансуудаар гүйлгээний эрхийг нээлгэж 23 төслийн гүйцэтгэлийг сар бүр хянаж 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн Уул уурхай хүнд үйлдвэрийн сайдын “Журам шинэчлэн батлах тухай” А/87 тушаалын дагуу 2024 оны 1,2,3,4,5,6,7,8,9,10,11,12 дугаар сарын гүйцэтгэлээр санхүүжилтийн тайланг Сангийн яаманд цаг хугацаанд нь хүргүүлэн ажиллав. Тайлант хугацаанд 1-12-р сарын гүйцэтгэлээр төлөвлөсөний дагуу 25,5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 23 төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжид олгосон байна. | | |
| 10 | Арга хэмжээ 5.2.7.1 Геологийн судалгааны ажлын аргачлал хяналтын зардлыг батлагдсан төсөв, хуульд нийцүүлэн худалдан авалт хийнэ. | 1 | 0 | 1 | Үндэсний геологийн албаны даргын 2024 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн А/07 дугаар тушаалаар Геологийн судалгааны ажлын 2024 оны аргачлал хяналтын зардлын төлөвлөгөө, төсвийг баталж, уг батлагдсан төсөвт нийцүүлэн сүүлийн жилийн байдлаар 560,0 сая төгрөгийн худалдан авалтыг зохион байгуулж ажиллав. Худалдан авалтын нийт 14 гэрээ | 2024. 01-12 сар | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгуулж, гэрээний хэрэгжилтийг хангуулан, гэрээний биелэлтийн актыг гэрээлэгч талтай үйлдэж, хүлээн авч баталгаажуулсан баримтын дагуу АҮЭБЯ-ны санхүүгийн хэлтсээр хянуулан худалдан авалтыг зохион байгуулж ажиллав. | | |
| 11 | Арга хэмжээ 5.2.8.1 Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцүүлэн төсвийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах, худалдан авалтын төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтийг тайлагнана. | 1 | 0 | 1 | Байгууллагын 2024 оны худалдан авах ерөнхий төлөвлөгөөг 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А/344 дүгээр тушаалаар батлуулсан. 2024 онд Харуул хамгаалалтын ажил үйлчилгээ үзүүлэх тухай тендерийг харьцуулалтын аргаар зарлаж "Шүтээн уул" ХХК, Мэдээлэл технологийн үйлчилгээ тендерийг харьцуулалтын аргаар зарлаж "Арвис системс ХХК, багаж техник хэрэгсэл тендерийг харьцуулалтын аргаар зарлаж "Ай Ти Зон" ХХК шалгарсан. Бичиг хэргийн материал худалдан авах тендер амжилтгүй болж цуцлагдсан бөгөөд шууд худалдан авалт хийж байна..<br>Мөн 2024 онд гүйцэтгэхээр төсөвт тусгагдсан ҮГА-ны байрны дээврийн засвар, ариун цэврийн өрөөнүүдийн засвар, барилгын дотоод засварын ажил үйлчилгээг худалдан авах ажиллагааг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаан ажиллаж байна. Эдгээр ажлуудыг ажлын даалгаварыг боловсруулахдаа тухайн хийж гүйцэтгэх ажлын зураг, төсвийг эхлэн боловсруулж, холбогдох эрх бүхий *төсөвчинтэй гэрээ байгуулж,* ажил үйлчилгээний *төсөв* болон түүнтэй холбогдох бусад тооцоо судалгааг гаргаж багц хэд хэдэн удаа зарлаж амжилтгүй болж дахин тендер зарлаад байна. | | |
| ЗОРИЛТ 5.5 Төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлэх | | | | | | | |
| 12 | Арга хэмжээ 5.5.1.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг | 12 | 0 | 6 | Үндэсний геологийн албаны 2024 оны хагас жилийн эцсийн байдлаарх санхүүгийн мэдээллийг шилэн дансанд хуулийн | 2024. 01-12 сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хангаж, орлого, зарлагын гүйлгээний мэдээллийг олон нийтэд нээлттэй мэдээлнэ. | | | | хугацаанд байршуулан ажилласан. Үүнд: Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх Геологи судалгааны ажлын санхүүжилт, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын гүйлгээ, тайлан, аудитлагдсан тайлан, аудитын гэрчилгээ, акт, албан шаардлага, бусад мэдээлэл багтаж байна.<br>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг дараах байдлаар тайлагнаж байна. Үүнд:<br>-Төсөв, санхүүтэй холбогдолтой төлөвлөгөө, тайлан,<br>-5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлого, зарлагын нийт 171 гүйлгээний мэдээллийг цаг хугацаанд нь олон нийтэд нээлттэй мэдээлсэн. | | |
| 13 | Арга хэмжээ 5.5.2.1 Төсвийн орлого болон зарлагын хэмжээ, хөрөнгө оруулалтыг тооцон, 2024 оны төсвийн тодотгол, 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийг боловсруулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ. | 1 | 0 | 1 | -Үндэсний геологийн албаны 2025 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал, 2025-2026 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөөллийг боловсруулан, 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 1/312 дугаар албан бичгээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлсэн.<br>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналыг Сангийн яамны хөрөнгө оруулалтын программ http://pimis.e-nation.mn/-д оруулсан.<br><br>Улсын төсөвт 2024 оны 11 дүгээр сарын байдлаар 264,0 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 2024 онд төвлөрүүлэх орлогоо давуулан биелүүлээд байна. | 2024. 01-12 сар | 100% |
| **Хоёр.** "Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг, үүргийг хэрэгжүүлэх,ажиллах" зорилтын хүрээнд<br>Зорилт 5.6 Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх | | | | | | | |
| 14 | Арга хэмжээ 5.6.1.1-Удирдах дээд байгууллагын | Хууль эрх зүйн хүрээнд цаг хугацаанд нь | 0 | Шаардлагатай тоо хэмжээгээр | | 2024-01.01-12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | удирдлагууд, даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт орж ажиллах, тушаал шийдвэрүүдийн хэрэгжилт болон удирдлага, хэлтсийн даргын өгсөн бусад үүргийн дагуу ажиллана. | хэрэгжүүлсэн байна. | | | | | |
| **Гурав. Мэдлэг, чадвараа дээшлүүлэх" зорилт, арга хэмжээний биелэлт** | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ №1. Төрийн албаны зөвлөл болон бусад байгууллагаас зохион байгуулсан сургалтад тухай бүр хамрагдах | Дунд болон богино хугацааны сургалтын хөтөлбөрт хамрагдах | 60% | Дунд болон богино хугацааны сургалтын хөтөлбөрт хамрагдсан байна | 2024 оны 10-р сард томилогдон ажиллаж байгаа тул сургалтанд хамрагдах боломж гараагүй байна. | 2024.0 10-12 сар | 0 |
| | | | | | | | |

ТАЙЛАН ГАРГАСАН:

Ахлах Нягтлан бодогч — Д.ДАВААДОЛГОР / ........................ / — 2024.11.27

*Албан тушаал )* — *( Овог нэр, гарын үсэг )* — *( Огноо )*